

Япон улс, Монгол улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ой  
Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв үүсгэн байгуулагдсаны 20 жилийн ой

# 14

## ЯПОН ХЭЛНИЙ БОЛОВСРОЛЫН СИМПОЗИУМ

### “Монгол дахь япон хэлний сургалтын хөтөлбөр-ICT-гийн хэрэглээ ба цаашдын төлөв”

#### Үндсэн илтгэлийн танилцуулга



#### Тагүчи Мана

Кёотогийн Их Сургуулийн дээд боловсролын судалгаа хөгжлийн төвийн дэд профессор, Оосакагийн Их Сургуулийн “Хүн судлал”-ын доктор

Оосакагийн Их Сургуулийн магистрын хөтөлбөрийг “Хүн судлал”-ын чиглэлээр төгссөн. Кёотогийн Их Сургуулийн дээд боловсролын судалгаа хөгжлийн төвийн дадлагажигч, медиа боловсролын хөгжлийн төвийн дэд профессороор ажилладаг. Харвардын Их Сургуулийн Derek Bok профессорын нэрэмжит боловсролын төвд зочин багшаар ажиллаж байгаад 2008 оноос Кёотогийн Их Сургуульд ажиллаж эхэлсэн.

Мэргэжлийн чиглэл: Мэдээлэл, технологийн боловсрол, их дээд сургуулийн боловсрол судлал

**Голлох бүтээл:** “Хичээлийн судалгаа ба мэдээлэл, технологийн боловсрол” (Минэрүва хэвлэлийн газар, 2012 он)

**Хамтын бүтээл:** “Ирээдүйн их, дээд сургуулийн багшийг хөгжүүлэх нь-Кёотогийн Их Сургуулийн уран зохиолын факультетийн багшийн хөтөлбөрөөр мэргэшиж буй магистрант, докторантанд зориулсан сургалт” (Кэисоо хэвлэлийн газар, 2013 он)

#### Илтгэлийн агуулга

Сэдэв: “Япон хэлний боловсролын сургалтын хөтөлбөр-ICT сургалтын хөгжил ба багшийн үүрэг”

Covid-19-ийн улмаас дэлхий дахинд онлайн сургалт, ICT-гийн хэрэглээнд ахиц дэвшил гарсан билээ. MOOC зэрэг нээлттэй контент мэдээллийн талаар ч хүмүүс мэддэг болсон. ICT бол суралцагчдын сурах үйл ажиллагааг дэмжиж чаддаг хүчирхэг хэрэгсэл гэж хэлж болно. Түүнчлэн, хэзээ ч хаана ч үзэж болох нээлттэй контентууд нь хүн бүрт сурч мэдэх боломж олгодог. Нээлттэй контент байхад багш хэрэггүй гэх ойлголт байдаг ч энэ нь өрөөсгөл ойлголт. Харин ч тийм нийгэмд л “Багш”-ийн үүрэг чухалд тооцогдоно. Багш хүн л оюутны байдлыг бодитоор үнэн зөв үнэлж, дүгнэн, сургалтыг явуулж чадна. Мөн багш хүн л “тасралтгүй суралцаж чадах суралцагч”-ийг бэлтгэн гаргаж чадна. Уг илтгэлд ICT сургалт өнөөг хүртэл хэрхэн хөгжиж ирсэн талаар авч үзэхийн сацуу сургалтын хөтөлбөр гэж юу болох талаар танилцуулна. Мөн өнөө цагт багш хүнд ямар үүрэг хариуцлага байх ёстой талаар та бүхэнтэй ярилцаж, санал бодлоо солилцмоор байна.

Илтгэлийн материалыг эндээс татаж авна уу. →



#### Хөтөлбөр

Огноо: 2022 оны 3 дугаар сарын 5 /Бямба гараг/ 10:00-17:00

Байр: Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвийн их танхимд

- 9:30 Бүртгэл эхлэх  
Хөтөлгч: Э.Тогтуун (Монгол Улсын Их Сургууль)
- 10:00 Нээлтийн үг: Э.Батжаргал (Монголын Япон багш нарын холбооны тэргүүн)  
Мэндчилгээ: Кобаяши Хироюки (Япон улсаас Монгол Улсад суугаа онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд)  
Мэндчилгээ: Ц.Даваадорж (Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвийн захирал)
- 10:30-12:00 **Үндсэн илтгэл (Асуулт, хариулт)**  
“Япон хэлний сургалтын хөтөлбөр-ICT сургалтын хөгжил ба багшийн үүрэг”  
Тагүчи Мана (Кёотогийн Их Сургуулийн Дээд боловсролын судалгаа, хөгжлийн төвийн дэд профессор)
- 12:30-13:30 **Үдийн цай**  
13:30-14:15 **Илтгэл 1 (Асуулт, хариулт)**  
“Монгол Улсын их сургуулиудад япон хэлтэй мэргэжилтэн бэлтгэх сургалтын хөтөлбөрийн өнөөгийн байдал –МУИС, МУБИС, ШУТИС–ийн жишээгээр”  
МУИС: д-р Ц.Дэлгэрэхцэг, д-р П.Энхжаргал, д-р Д.Майсүлд  
МУБИС: Н.Баярмаа  
ШУТИС: Б.Ундармаа, С.Оюундэлгэр
- 14:15-15:00 **Илтгэл 2 (Асуулт, хариулт)**  
“Монголын бага, дунд сургуулийн япон хэлний сургалтын хөтөлбөр, онлайн хичээлийн талаар авч үзэх нь”  
Монгени цогцолбор сургууль: Наканиши Рейко  
Эрдмийн ундраа цогцолбор сургууль: Т.Энхпүрэв  
Өвөрхангай аймгийн лаборатори Мэргэд сургууль: Д.Дуламсүрэн  
84-р сургууль: Б.Нямлхагва  
Наран сургууль: Ц.Цэцэгмаа
- 15:00-15:30 **Завсарлага**  
15:30-16:15 **Илтгэл 3 (Асуулт, хариулт)**  
“Монгол дахь сургалтын төвүүдийн япон хэлний сургалтын өнөөгийн байдал”  
Монгол Японы Залуучуудын Хамтын Ажиллагааг Дэмжих Төв:  
Л.Жавзандулам, М.Оюунбилэг  
Фүжи япон хэлний сургалтын төв: Б.Тэгшзаяа  
HR bridge япон хэлний сургалтын төв: Д.Батгэрэл  
Санрайс япон хэлний сургалтын төв: Х.Жанболат  
Васэда япон хэлний боловсролын төв: Ц.Амгалан  
Юү лангүэж сургалтын төв: Л.Золзаяа  
Юүгэн япон хэлний сургалтын төв: Д.Оюунсүрэн  
Дэкирү япон хэлний сургалтын төв: Д.Туул, Э.Болорсүвд  
Цүүякү япон хэлний сургалтын төв: Н.Ариунжаргал  
Кизүна япон хэлний сургалтын төв: Ж.Ариунтуяа  
Мүгэн япон хэлний сургалтын төв: Р.Мөнгөнцэцэг
- 16:15-17:00 **Дүгнэлт:** Мицүмото Томоя (Японы сангийн мэргэжилтэн)  
**Хурлын хаалт:** Ц.Пүрэвсүрэн /Монголын Япон Хэлний Багш нарын Холбооны дэд тэргүүн/  
Дурсгалын зураг  
Хүлээн авалт
- 17:00

Зохион байгуулагч: Монголын Япон Хэлний Багш нарын Холбоо  
Хамтран зохион байгуулагч: Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв

Япон улсын засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Япон сан  
Дэмжигч: Япон улсын Элчин Сайдын Яам

